



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/207

Мандалговь

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар  
Соёлын сайдын багцаар хэрэгжиж буй  
“Их соёл-Эх үндэс” хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдэх бараа,  
тоног төхөөрөмж хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.5, Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 4.3.4 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Их соёл-Эх үндэс” хөтөлбөрийн хүрээнд “Цахим музей”- Багц 1, “Дуу бичлэгийн студи”-Багц 2, “Гадна дэлгэц”- Багц 3 ажилд нийлүүлэгдэх бараа, тоног төхөөрөмж хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Энхтуяа-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичиг: С.Намжилмаа-(Боловсрол, соёл урлагийн газрын Соёлын өв хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: М.Бямбажав-(Музейн дарга)  
А.Ууганбаяр-(Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын дарга)  
М.Болор-Эрдэнэ-(Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн )  
Б.Цолмонгэрэл-(Төв халхын дуулалт жүжгийн театрын маркетингийн менежер)  
Б.Сугарсүрэн-(Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын нярав)

2.Батлагдсан гэрээний дагуу бараа, тоног төхөөрөмжийг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Д.Энхтуяа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



468210791